



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А1107

Номгон

Г Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтад хяналт тавих тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын 2024 оны 04/27 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 71 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг 2025 оны 03 дугаар сарын 05-наас 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.


2. Дээрх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулахад шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчны газар (Э.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

4. Хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайланг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн архивын тасагт хүлээлгэн өгч, танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Ням-очир)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

625010329

Аймгийн Засаг даргын 02-ны
дугаар сарын 26-ны өдрийн 1707 дугаар
захирамжийн хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ням-очир Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга

Гишүүд:

Б.Намуун Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн

Ц.Доржнамжин Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Уул
уурхайн, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан
мэргэжилтэн

Б.Зүгдоржав Байгаль орчны газрын Усны асуудал, Төрийн бус
байгууллага, судалгаа шинжилгээ хариуцсан
мэргэжилтэн

Л.Энхтогтох Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Усны
чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Холбогдох сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Г.Нансалмаа Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны
Гадаргын усны нөөц, хяналт шинжилгээний асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн